



"Ай Жэй Эй Эйч-Аудит" ХХК

“БЭРХ-УУЛ” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон
Санхүүгийн аудитын тайлан

Улаанбаатар хот

2026

АГУУЛГА

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ	2
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ЗАХИДАЛ.....	3
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	5
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	8
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	9
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	10
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	11
ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	12
ТОДРУУЛГА 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ.....	12
ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗҮЙЛС.....	19
ТОДРУУЛГА 4. АВЛАГА.....	19
ТОДРУУЛГА 5. БАРАА МАТЕРИАЛ.....	19
ТОДРУУЛГА 6. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО.....	19
ТОДРУУЛГА 7. ҮНДСЭН ХӨРӨНГӨ	19
ТОДРУУЛГА 8. БИЕТ БУС ХӨРӨНГӨ.....	20
ТОДРУУЛГА 9. БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ.....	20
ТОДРУУЛГА 10. ХАЙГУУЛ ҮНЭЛГЭЭНИЙ ХӨРӨНГӨ.....	20
ТОДРУУЛГА 11. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР.....	21
ТОДРУУЛГА 12. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ БОЛОН УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР.....	21
ТОДРУУЛГА 13. ХУВЬЦААТ КАПИТАЛ.....	21
ТОДРУУЛГА 14. ХУРИМТЛАГДСАН АШИГ/АЛДАГДАЛ.....	21
ТОДРУУЛГА 15. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО.....	21
ТОДРУУЛГА 16. БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ	22
ТОДРУУЛГА 17. ЕРӨНХИЙ УДИРЛАГЫН ЗАРДАЛ.....	22
ТОДРУУЛГА 18. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО, ЗАРДАЛ.....	22
ТОДРУУЛГА 19.ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ.....	23

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Компанийн нэр /Оноосон нэр/	Монгол	" БЭРХ УУЛ" ХК
Компаний удирдлага	А.Даваажав	Гүйцэтгэх захирал
Компанийн хаяг:	Хэнтий аймаг, Батноров сум, 7-р баг, Бэрх тосгон, 1-р хороо, "Бэрх Уул" ХК-ийн байр. Утас: (976)-75859505, 99079157 Факс: (976)-75859505	
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:	1810002001	
Регистрийн дугаар:	2643928	
Бүртгэгдсэн он сар	2001 оны 10 дугаар сарын 11	
Үйл ажиллагааны чиглэл	Алт олборлолт, Жонш олборлолт, Чулуун нүүрс олборлолт, Уур үйлдвэрлэл, халуун ус хангамж, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл явуулах үйлчлэх үйл аж, Барилга байгууламжийн засвар үйлчилгээ	
Санхүү	Ж.Пүрэвдорж	Ерөнхий нягтлан бодогч
Ажилчдын тоо	 ажилчидтай	
Аудитын компани	"Ай Жэй Эй Эйч -Аудит" ХХК Нягтлан бодох бүртгэл, татвар, санхүүгийн хяналт баталгаажуулалтын итгэмжлэгдсэн хөндлөнгийн байгууллага	
Аудитын компанийн хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15-р хороо, Намьяанжүгийн гудамж, "Copper plaza" 501, 502 тоот Утас: 976-77450279, 99040059 Факс: 976-77450279	

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Энэхүү тайлангийн 5-7 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Бэрх Уул" Хувьцаат Компанийн /Компани гэх/ 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг ялгах үүднээс хийгдсэн болно.

Удирдлага нь компанийн санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байх ёстой.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага нь дараах зүйлсэд хариуцлага хүлээдэг. Үүнд:

- ✓ Тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлого сонгож, тууштай мөрдөх
- ✓ Ул үндэстэй, хянамгай шийдэл гаргах болон тооцоолол хийх
- ✓ СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурдаж, хэрэв материаллаг ялгаа буюу өөрчлөлт байгаа бол санхүүгийн тайланд тодруулж, тайлбарлах
- ✓ Компани ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг үйл ажиллагааны суурийг үндэслэж бэлтгэх

Удирдлага нь түүнчлэн,

- ✓ Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловруулж, хэрэгжүүлж ажиллуулах
- ✓ Компаний санхүүгийн байдлыг аливаа хугацаанд үнэн зөвөөр харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх
- ✓ Компаний нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- ✓ Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- ✓ Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.
- ✓ Санхүүгийн тайланг батлах өдөр болон энэхүү захидал зурагдах өдрийн хооронд санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхүйц өөр үйл явдал гараагүй

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

“Бэрх Уул”ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.



А.Даваажав
/Гүйцэтгэх захирал/

Ж.Пүрэвдорж
/Ерөнхий нягтлан бодогч/



2026 он 04 сар 27 өдөр

№ 103/2026

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“БЭРХ УУЛ” ХК -ийн хувьцаа эзэмшигч танаа

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

Зөрчилгүй дүгнэлт

“Бэрх Уул” ХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Бэрх Уул” ХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартуудын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Энэхүү компани нь бусад мэдээлэл буюу жилийн тайлан бэлтгэдэггүй.

Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас илэрхийлж байгаа мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, залилан болон алдаанаас үүдэх материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг тодорхойлж мөрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах эрх бүхий этгээдүүд нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн талаархи аудиторовн хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан болон алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үл үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторовн тайлан бэлтгэх явдал юм. Үл үндэстэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа бүх буруу тайлагналыг үргэлж илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу тайлагнал нь залилан эсвэл алдаанаас шалтгаалан үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдлийг тодорхойлж үнэлэн, уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай нотолгоог олж авсан. Залилангаас үүдэлтэй материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах явдлууд орсон байж болно.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад

хангалттай дурьдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсч болох юм.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлсэн.

Бид аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналт дахь зөрчил дутагдал, сул талуудыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлаар засаглах эрх бүхий этгээдтэй харилцдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасан компанийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ай Жэй Эй Эйч Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот

Огноо: 2026.04.27

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

	/мянган.төгрөгөөр/	
	2024	2025
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	25,278.4	37,157.0
Дансны авлага	918,884.2	889,211.6
Татвар, НДШ-ийн авлага	66,008.5	66,008.5
Бусад авлага	43,921.2	50,944.3
Бараа материал	40,671.0	229.6
Урьдчилж төлсөн зардал тооцоо	53,763.2	65,723.6
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,148,526.7	1,109,274.7
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,143,657.7	1,082,430.9
Биет бус хөрөнгө	6,041.3	-
Биологийн хөрөнгө	3,400.0	3,400.0
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	2,790,040.1	2,790,040.1
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	2,267,630.7	2,267,630.7
Эргэлтийн бус хөрөнгө	193,955.0	193,955.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,404,724.8	6,337,456.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,553,251.5	7,446,731.4
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	2,406,649.8	2,557,841.5
Цалингийн өглөг	248,844.2	215,906.0
Татварын өр	1,595,692.7	1,647,000.2
НДШ-ийн өглөг	280.1	-
Богино хугацаат зээл	742,781.9	687,557.5
Хүүний өглөг	22,784,887.3	23,143,950.7
Урьдчилж орсон орлого	12,319.9	309,540.6
Богино хугацаат өр төлбөрийн дүн	27,791,455.9	28,561,796.5
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	3,153,229.7	3,274,926.6
Нөөц/өр төрбөр/	4,954,016.7	4,954,016.7
Урт хугацаат өр төлбөрийн дүн	8,107,246.4	8,228,943.3
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	35,898,702.3	36,790,739.8
Эздийн өмч		
Өмч / хувийн /	1,906,208.0	1,906,208.0
Хөрөнгийн дахин үнэлгээний	1,990,685.2	1,990,685.2
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	(32,242,344.0)	(33,240,901.6)
Эздийн өмчийн дүн	(28,345,450.8)	(29,344,008.4)
Нийт өр төлбөр, өмчийн дүн	7,553,251.5	7,446,731.4

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

ОРЛОГЫН ТАЙЛАН

2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

	/мянган.төгрөгөөр/
	2025
Борлуулалтын орлого	1,769,056.3
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	991,793.5
Нийт ашиг (алдагдал)	777,262.8
Хүүний орлого	79.1
Бусад орлого	26,061.7
Борлуулалт маркетингийн зардал	-
Ерөнхий ба удирдлагын зардал	670,708.51
Бусад зардал	31,626.55
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(1,057,143.5)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны (гарз)	(32,468.5)
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-
Бусад ашиг (алдагдал)	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(988,543.4)
Орлогын татварын зардал	10,014.2
Татварын дараах ашиг (алдагдал)	(998,557.6)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(998,557.6)
Бусад дэлгэрэнгүй орлого	-
Бусад олз гарз	-
Орлогын нийт дүн	(998,557.6)

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

/мянган.төгрөгөөр/

	Хөрөнгийн			Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
	Хувьцаат капитал	дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг		
2024 оны 12 сарын 31	1,906,208.00	1,990,685.16		(32,242,343.96)	(28,345,450.80)
Гаргасан хувьцаат капитал					-
Залруулсан үлдэгдэл	1,906,208.00	1,990,685.16		(32,242,343.96)	(28,345,450.80)
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал				(998,557.61)	(998,557.61)
Бусад дэлгэрэнгүй орлого					-
2025 оны 12 сарын 31	1,906,208.00	1,990,685.16		(33,240,901.57)	(29,344,008.40)



Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

	/мянган.төгрөгөөр/
	2025
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-
Мөнгөн орлогын дүн (+)	2,280,971.43
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,200,340.99
Бусад мөнгөн орлого	80,630.43
Мөнгөн зарлагын дүн (-)	2,504,697.84
Ажилчдад төлсөн	368,189.19
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	87,914.51
Бараа материал худалдан авахад төлсөн	-
Ашиглалтын зардалд төлсөн	137,417.83
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	980,060.25
Хүүний төлбөрт төлсөн	525,175.56
Татварын байгууллагад төлсөн	162,087.76
Даатгалын төлбөрт төлсөн	247.19
Бусад мөнгөн зарлага	243,605.57
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(223,726.42)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн (+)	49,779.10
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	49,700.00
Хүлээн авсан хүүний орлого	79.10
Мөнгөн зарлагын дүн (-)	76,680.87
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	30,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,159.19
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	45,521.68
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(26,901.76)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-
Мөнгөн орлогын дүн (+)	595,714.59
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	595,700.00
	14.59
Мөнгөн зарлагын дүн (-)	333,207.82
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	333,207.82
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	262,506.77
Валютын ханшийн зөрүү	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	11,878.59
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,278.45
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,157.04
Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.	



ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Бэрх Уул” ХК нь үүсгэн байгуулагчийн 2006 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн тогтоол, баталсан дүрмийн дагуу хувьцаат компанийн хэлбэрээр зохион байгуулагдсан. 2012 оны эцэст эцсийн өмчлөгч 103 хүнээр бүртгэгдсэн байна.

Компани нь орлого ашгаа арвижуулах замаар хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх явдлыг үндсэн зорилгоо болгон үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна. Үүнд:

- Алт олборлолт
- Жонш олборлолт
- Чулуун нүүрс олборлолт
- Уур үйлдвэрлэл, халуун ус хангамж
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл явуулах үйлчлэх үйл аж
- Барилга байгууламжийн засвар үйлчилгээ

ТОДРУУЛГА 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

2.1 Нягтлан бодох бүртгэлийн үндэс

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт цаашид (СТОУС гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар болон Монгол улсын зохих хууль, тогтоомжийг үндэслэн бэлтгэсэн.

2.2 Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэсэн валют

Компаний үйл ажиллагааны валют нь Монгол улсын үндэсний валют төгрөг юм.

2.3 Үнэлгээ

Санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэдэг.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн суурь

Компани нягтлан бодох бүртгэлийн аккурэль суурьд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

2.5 Санхүүгийн тайлан бэлтгэх төсөөлөл

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн. Тасралтгүй үйл ажиллагааны зарчмын төсөөлөл хүчинтэй байх эсэх нь компани ирээдүйд тасралтгүй үйл ажиллагаагаа хадгалж чадах эсэхээс хамаарна.

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх нь удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тайлагнасан дүн зэрэгт нөлөөлөх үнэлгээ, таамаглал ба тооцоолол хийхийг шаарддаг. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлгээ тооцоолол болон гол чухал таамаглалууд нь байнга шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг тухайн өөрчлөлт хийгдсэн болон ирээдүйд нөлөөлөх тайлант үеүдэд нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдэд материаллаг нөлөө үзүүлэхээр нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хэрэглээ, тооцооллын эргэлзээтэй асуудал байхгүй болно.

2.6 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалттай банкин дахь харилцах дансуудаас бүрдэнэ. Мөнгө түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр бүртгэдэг.

2.7 Гадаад валютын гүйлгээ

Гадаад валютаархи мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг.

Түүхэн өртгөөр тодорхойлогдсон гадаад валютаархи мөнгөн бус зүйлсийг түүний өртгийг тодорхойлох үед байсан албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг.

Зах зээлийн үнээр илэрхийлэгдсэн гадаад валютаархи мөнгөн бус зүйлсийг түүний өртгийг тодорхойлох үед байсан албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн үлдэгдэлд балансын өдрөөр Монгол банкнаас зарласан албан ханшаар ханшийн тэгшитгэлийн олз, гарзаар хүлээн зөвшөөрдөг. Энэ нь ханшийн зөрүүгийн бодит бус олз ба гарз байна.

2.8 Авлага

Байгууллага, иргэдэд буцаан төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон мөнгө, татвар, шимтгэлийн авлагыг бусад авлагаар бүртгэдэг. Эдгээр авлагыг тухайн үеийн нэхэмжлэх дүнгээр тайлагнадаг. Авлагын хувьд насжилт, цуглуулагдах магадлалыг үнэлэн найдваргүй авлагын нөөцийн сан байгуулдаггүй.

2.9 Бараа материал

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана. Бараа материалын өртгийг жигнэсэн дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд худалдан авалт, боловсруулалт, байршуулалт зэрэг тухайн байрлал, нөхцөлд авчирах хүртэлх зардлыг өртөгт шингээнэ.

2.10 Урьдчилж төлсөн зардал, тооцоо

Худалдан авах бараа, үйлчилгээний үнийн урьдчилгаа, дараагийн тайлант үед хамаарах зардлыг урьдчилж гарсан зардал, тооцоо дансанд бүртгэдэг. Урьдчилж төлсөн зардал, тооцоог тайлант үеийн холбогдох хөрөнгө, зардал дансад хамаарна.

2.11 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

Анхны өртөг нь хөрөнгийг худалдан авсан үнэ дээр түүнийг олж бэлтгэхэд гарсан зардал, капиталжуулсан засварын зардлыг нэмсэн дүнгээс бүрддэг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүнийг ашиглалтанд орсон хугацаанаас эхэлж, хөрөнгийн ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцож байгуулдаг.

Элэгдэл тооцох арга болон хугацаа нь Монгол улсын "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн заалтад нийцэх бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацаа дараах байдалтай байна.

<u>Үндсэн хөрөнгийн төрөл</u>	<u>ашиглагдах хугацаа (жилээр)</u>
Барилга, байгууламж	25
Уул уурхайн тоног төхөөрөмж	10

Тээврийн хэрэгсэл	10
Тавилга, эд хогшил	10
Компьютер, дагалдах хэрэгсэл	2
Бусад хөрөнгө	10

Үндсэн хөрөнгөнд хийсэн урсгал болон их засварын зардлыг засвар хийх тухай бүр тооцож бүртгэнэ.

Засварын зардал нь үндсэн хөрөнгийн анхдагч үнэлгээний үед тогтоосон бүтээмжийг дээшлүүлэхүйц, компанийн хүртэх ирээдүйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэхүйц, ашиглагдах хугацааг уртасгахаар байвал тэдгээрийг капиталжуулах ёстой. Бусад засварын зардлыг урсгал засвар гэх бөгөөд тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа үлдэгдэл өртгийн дүнгээр хөрөнгө данснаас хассаны гарзыг, худалдан борлуулах үед хөрөнгийн үлдэгдэл өртөг, худалдсан үнийн зөрүүгээр хөрөнгө худалдан борлуулсны олз, гарзыг хүлээн зөвшөөрдөг

2.12 Биет бус хөрөнгө

Ажил үйлчилгээний нийлүүлэлтэд болон удирдлагын зориулалтаар ашиглахаар эзэмшиж байгаа биет шинж чанаргүй, харьцангуй удаан хугацаагаар ашиглагдах хөрөнгийг биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Биет бус хөрөнгийн хорогдуулгыг хөрөнгийн ашиглагдах жилийг үндэслэн шулуун шугамын аргаар тооцдог.

Биет бус хөрөнгийн хорогдуулгыг тооцох арга болон хугацаа нь Монгол улсын "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн заалтад нийцэх бөгөөд биет бус хөрөнгийн хорогдуулга тооцох хугацаа дараах байдалтай байна.

Ангилал	Ашиглагдах хугацаа (жилээр)
Программ хангамж	3
Ашиглагдах хугацаа нь тодорхойгүй биет бус хөрөнгө	10
Ашиглагдах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө	хүчин төгөлдөр байх хугацаа

2.13 Дансны өглөг

Компаний үндсэн үйл ажиллагаатай холбогдон зээлээр худалдан авсан бараа, материалын үнэ, хүлээн авсан үйлчилгээний үнэ болон үйл ажиллагааны зардыг хуримтлуулснаас үүссэн өглөгийг дансны өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Дансны өглөгийг худалдан авсан бараа, үйлчилгээний нэрлэсэн үнээр бүртгэдэг.

2.14 Цалингийн өглөг

Ажилтан, албан хаагчдад өгөх цалин, бусад хэлбэрийн хөдөлмөрийн хөлсний өр төлбөрийн дүн хамаарна. Ажилтан тайлант хугацаанд аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд аж ахуйн нэгж нь төлбөл зохих богино хугацааны тэтгэмжийг дискаунтчилаагүй дүнгээр нь зардал байдлаар, уг дүнгээс төлөгдсөн хэсгийг хассан дүнгээр өр төлбөрөөр бүртгэнэ. Харин зардлын дүнгээс илүү төлөгдсөн байвал урьдчилж төлсөн зардлаар бүртгэнэ.

2.15 Татварын өглөг

Монгол улсын хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт төлж байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, хураамжийн өр төлбөрийг татварын өглөг гэж ангилсан.

2.16 Банкны богино хугацаат зээл

Богино хугацаагаар буюу нэг жилээс доош хугацаанд төлөхөөр авсан зээлийг богино хугацаат өр гэж үзэж энэ хэсэгт тусгана.

2.17 Урьдчилж орсон орлого

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэхээс өмнө тэдгээрийн үнийг худалдан авагч эсвэл захиалагчаас урьдчилан хүлээн авсан тохиолдолд хүлээн авсан мөнгөний хэмжээгээр богино хугацаат өр үүсгэж "Урьдчилж орсон орлого" дансанд бүртгэнэ.

2.18 Нөөц ба бусад өр төлбөр

Нөхөн төлөгдөх нөөцийн тооцоолол нь нөөцийн хэмжээ болон чанарыг тооцоход шаардлагатай геологийн төсөөлөл, үнэлэмжээс гадна гадаад валютын ханш, түүхий эдийн үнэ, ирээдүйн өөрийн хөрөнгийн шаардлага, үйлдвэрлэлийн зардал гэх мэт хүчин зүйлсэд үндэслэсэн. Нөөцийн тооцооллын өөрчлөлт нь үйлдвэр, тоног төхөөрөмжийн бүртгэлийн дүн, уурхайн нөхөн сэргээлтийн нөөц, хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө болон элэгдлийн зардлын хүлээн зөвшөөрөлтөнд нөлөө үзүүлж болно.

2.19 Бусад өглөг

Компаний ажиллагчидтай цалин, тэтгэвэр болон бусад тооцоогоор үүссэн өглөг болон бусад аж ахуй нэгж, иргэдтэй үүссэн дансны өглөгөөс бусад өр төлбөрийг бусад өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

2.20 Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөрт нэг жилээс дээш хугацаанд төлөх бусад байгууллага, хувь хүнд өгөх өглөгийг бүртгэдэг.

Компани үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгө худалдан авах, уурхай баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалт болон ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лицензтэй холбоотой зардал, үйл ажиллагааны зардлын санхүүжилтэд зориулж хувь нийлүүлэгчээс авсан санхүүжилтыг урт хугацаат өр төлбөрт бүртгэнэ.

2.21 Нүүрсний нөөц

Нүүрсний нөөц нь компанийн уурхайн өмчөөс эдийн засгийн болон хууль ёсны дагуу гарган авах боломжтой нүүрсний тооцоолсон дүн юм. Компани нь нүүрсний нөөцийн хэмжээ, гүн, хэлбэрийн талаарх геологийн тоо баримттай холбоотой мэдээллүүдийг зохих мэргэжилтэн нэгтгэсэн мэдээлэл дээр үндэслэн нүүрсний нөөцийг тооцоолсон байна. Нөхөн төлөгдөх нөөцийн тооцоолол нь нүүрсний нөөцийн хэмжээ болон чанарыг тооцоход шаардлагатай геологийн төсөөлөл, үнэлэмжээс гадна гадаад валютын ханш, түүхий эдийн үнэ, ирээдүйн өөрийн хөрөнгийн шаардлага, үйлдвэрлэлийн зардал гэх мэт хүчин зүйлсэд үндэслэсэн. Нөөцийн тооцооллын өөрчлөлт нь үйлдвэр, тоног төхөөрөмжийн бүртгэлийн дүн, уурхайн нөхөн сэргээлтийн нөөц, хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө болон элэгдлийн зардлын хүлээн зөвшөөрөлтөнд нөлөө үзүүлж болно.

2.22 Эзэмшигчдийн өмч

Эзэмшигчдийн өмч нь хувьцаа эзэмшигчээс оруулсан хөрөнгө, хуримтлагдсан ашгаас бүрдэнэ. Эзэмшигчдийн өмчийг түүхэн өртгөөр нь санхүүгийн тайланд илэрхийлдэг.

Хувьцаат капитал нь эзэмшигчдээс оруулсан энгийн хувьцааны дүнгээр илэрхийлэгдэх бөгөөд нийт дүн нь нэгж хувьцааны нэрлэсэн үнийг нийт хувьцааны тоогоор үржүүлсэн дүн байна.

Хуримтлагдсан ашиг, алдагдал нь өмнөх болон тайлант жилүүдийн үйл ажиллагааны цэвэр дүнг илэрхийлдэг бөгөөд нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг.

2.23 Цэвэр хөрөнгө

Хуримтлагдсан ашиг, алдагдал нь өмнөх болон тайлант жилүүдийн үйл ажиллагааны цэвэр дүнг илэрхийлдэг бөгөөд нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг.

2.24 Дахин үнэлгээний нэмэгдэл

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнээс үүссэн нэмэгдлийг энэ хэсэгт үзүүлнэ.

2.25 Орлого

i) Орлого нь хүлээн авсан, эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй бодит үнэ цэнээр хэмжигдэнэ.

ii) Борлуулсан бүтээгдэхүүн

Борлуулсан бүтээгдэхүүнээс олсон орлогыг буцаалт, худалдааны болон тоо хэмжээний хөнгөлөлтийн дүнг хассан цэвэр дүнгээр хүлээн авсан эсвэл хүлээн авах бодит үнэ цэнээр хэмждэг.

Дараах нөхцлүүд хангагдсан тохиолдолд борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрдөг.Үүнд:

- (a) тухайн бүтээгдэхүүний өмчлөлийн голлох эрсдэл болон өгөөжийг худалдан авагчид шилжүүлсэн;
- (b) борлуулсан барааны удирдлага болон хяналтын аль аль нь компанид үлдээгүй;
- (c) хүлээн зөвшөөрөх орлогын хэмжээ нь хэмжиж болохоор байх;
- (d) ажил гүйлгээний урсгал нь компанид эдийн засгийн өгөөж өгөх магадлалтай байх;
- (e) ажил гүйлгээтэй холбоотой гарсан болон гарах өртөг, буцаалтын тооцооллыг найдвартай хэмжих боломжтой байх.

iii) Үйлчилгээний орлого

Үйлчилгээ үзүүлсэн тухайн үед нь үйлчилгээний орлогыг хүлээн зөвшөөрдөг. Үйлчилгээг хэрэглэгчдэд үзүүлээгүй үед хүлээн авсан орлогыг хойшлуулсан орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

2.26 Борлуулалт маркетингийн зардал

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчдэд хуваарилсанаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

Компанийн удирдлагын болон үндсэн үйл ажиллагаанд хамаарах зардлыг үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрөх ба үйл ажиллагааны зардлыг тайлант хугацаанд ногдох дүнгээр нь бүртгэдэг.

А.Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардал

Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардлыг мөнгөөр төлөгдсөнөөс нь үл хамаарч гарсан тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Б.Санхүүгийн орлого ба зардал

Санхүүгийн орлогод дансны үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлогыг хамааруулна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

Санхүүгийн зардалд зээлийн хүүгийн зардал хамааруулна. Зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

2.27 Татварын зардал

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татварын өглөг ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм. Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг татвар ногдуулах нэг аж ахуйн нэгжид хамаарах татварын байгууллагаас тогтоосон тайлант үеийн татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөрийн эсрэг хуулийн эрх үүргийн дагуу хооронд нь хааж болох бөгөөд гэхдээ эдгээр татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөр нь цэвэр дүнд суурилсан байх хэрэгтэй.

Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрт хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

2.28 Компаний орлогын албан татвар

Компани санхүүгийн жилийн татвар ногдуулах орлого, түүнд ногдуулсан орлогын албан татварыг Монгол улсын "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн дагуу тодорхойлж тайлагнадаг.

Тухайн хуулийн дагуу 6.0 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдуулах жилийн орлогод, 10 хувиар, 6.0 тэрбум төгрөгөөс дээш татвар ногдуулах жилийн орлого олсон бол 600.0 сая төгрөг дээр 6.0 тэрбумаас дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж, орлогын албан татвар ногдуулж төлдөг.

2.29 Хувь хүний орлогын албан татвар

Монгол улсын "Хувь хүний орлогын албан татварын тухай" хуулиар компани ажиллагсад болон гэрээт ажилчдад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогоос 10 хувиар хувь хүний орлогын албан татварыг суутгаж төсөвт төлөх үүрэг хүлээдэг. Мөн оршин суугч бус татвар төлөгчид шилжүүлсэн орлогоос "Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар"-ын тухай хуулийн дагуу 20 хувиар дундын суутгал хийдэг. Давхар татвар ногдуулахаас зайлсхийх тухай Олон улсын хэлэлцээр бүхий улс орны оршин бус татвар төлөгчдийн хувьд энэхүү татварын түвшинг (0) хүртэл бууруулдаг.

2.30 Нийгмийн даатгалын шимтгэл

Монгол улсын "Нийгмийн даатгалын тухай" хуулийн дагуу компани ажиллагсад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогын дүнгээс даатгуулагчаас 11.5 хувиар, ажил олгогчоос 12.5 хувиар тооцож нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх үүрэг хүлээдэг.

2.31 Нэмэгдсэн өртгийн албан татвар

Монгол улсын "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" хуулиар нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) ногдох бараа, ажил үйлчилгээний орлогод 10 хувиар тооцож НӨАТ төлдөг.

Мөн хуулиар НӨАТ ногдох бараа, ажил үйлчилгээний орлогын хэмжээ хуулийн этгээдийн орлогын албан татварын тайлангаар 50.0 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн өдрийн дараа сараас НӨАТ төлөгчөөр бүртгүүлдэг.

Үндсэн үйлдвэрлэл, ажил үйлчилгээний борлуулалтын орлого 50.0 сая төгрөгт хүрсэн эсэхээс үл хамааран Монгол улсад 2.0 сая ам.доллар ба түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн хуулийн этгээд сайн дураараа НӨАТ төлөгч болно.

ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗҮЙЛС

Тайлант хугацааны эцсээрх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

	2024	2025
Кассад байгаа бэлэн мөнгө /төгрөг/	23,233.6	26,787.7
Банкин дахь харилцах дансны үлдэгдэл /төгрөг/	2,044.8	10,369.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	25,278.4	37,157.1

Мөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалттай банкин дахь төгрөгийн болон долларын харилцах дансуудаас бүрдсэн байна.

ТОДРУУЛГА 4. АВЛАГА

	2024	2025
Дансны авлага	918,884.2	889,211.6
Татвар, НДШ- ийн авлага	66,008.5	66,008.5
Бусад авлага	43,921.2	50,944.3
Авлагын дүн	1,028,813.9	1,006,164.4

ТОДРУУЛГА 5. БАРАА МАТЕРИАЛ

	2024	2025
Бараа материал	229.6	229.6
Бусад	40,441.5	-
Бараа материалын дүн	40,671.1	229.6

ТОДРУУЛГА 6. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ ТООЦОО

	2024	2025
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	53,763.2	65,723.6
Урьдчилж төлсөн зардал/ тооцооны дүн	53,763.2	65,723.6

ТОДРУУЛГА 7. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

А. Үндсэн хөрөнгийн тайлант оны хөдөлгөөнийг харуулбал дараах байдалтай байна.

	2024	2025
Газрын сайжруулалт	36,579.0	36,263.2
Барилга байгууламж	811,063.1	712,995.4
Машин, тоног төхөөрөмж	544,174.3	544,174.3

Тээврийн хэрэгсэл	152,700.0	262,700.0
Тавилга эд хогшил	114,400.6	114,400.6
Компьютер, бусад хэрэгсэл	27,586.1	27,586.1
Үндсэн хөрөнгийн дүн	1,686,503.1	1,698,119.6

Б. Хуримтлагдсан элэгдэл

	2024	2025
Барилга байгууламж	173,009.1	175,291.0
Машин, тоног төхөөрөмж	182,130.4	227,451.8
Тээврийн хэрэгсэл	51,627.8	75,097.2
Тавилга эд хогшил	112,605.7	113,066.1
Компьютер, бусад хэрэгсэл	23,472.4	24,782.6
Үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн	542,845.4	615,688.7

ТОДРУУЛГА 8. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

А. БИЕТ БУС ХӨРӨНГӨ /ӨРТӨГ/

	2024	2025
Компьютерийн программ хангамж	1,383.8	1,383.8
Тусгай зөвшөөрөл	7,573.4	8,732.6
Биет бус хөрөнгийн дүн	8,957.2	10,116.4

Б. Хуримтлагдсан хорогдол

	2024	2025
Компьютерийн программ хангамж	1,383.8	1,383.8
Тусгай зөвшөөрөл	1,532.2	8,732.6
Биет бус хөрөнгийн хорогдлын дүн	2,916.0	10,116.4

ТОДРУУЛГА 9. БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

	2024	2025
Биологийн хөрөнгө	3,400.0	3,400.0
Биологийн хөрөнгийн дүн	3,400.0	3,400.0

ТОДРУУЛГА 10. ХАЙГУУЛ ҮНЭЛГЭЭНИЙ ХӨРӨНГӨ

	2024	2025
--	------	------

Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	2,790,040.1	2,790,040.1
Хайгуул ба үнэлгээний хөрөнгийн дүн	2,790,040.1	2,790,040.1

ТОДРУУЛГА 11. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

	2024	2025
Дансны өглөг	2,406,649.8	2,557,841.5
Цалингийн өглөг	248,844.2	215,906.0
Татварын өр	1,595,692.7	1,647,000.2
НДШ-ийн өглөг	280.1	-
Богино хугацаат зээл	742,781.9	687,557.5
Хүүний өглөг	22,784,887.3	23,143,950.7
Урьдчилж орсон орлого	12,319.9	309,540.6
Богино хугацаат өр төлбөрийн дүн	27,791,455.9	28,561,796.5

ТОДРУУЛГА 12. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ БОЛОН УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

	2024	2025
Урт хугацаат зээл	3,153,229.7	3,274,926.6
Нөөц /өр төлбөр/	4,954,016.7	4,954,016.7
Урт хугацаат зээл болон урт хугацаат өр төлбөрийн дүн	8,107,246.4	8,228,943.3

ТОДРУУЛГА 13. ХУВЬЦААТ КАПИТАЛ

	2024	2025
Хувийн өмч	1,906,208.0	1,906,208.0
Хувьцаат капиталын нийт дүн	1,906,208.0	1,906,208.0

Компаний хувь нийлүүлсэн хөрөнгө нь 1,906,208.0 мянган төгрөг байна.

ТОДРУУЛГА 14. ХУРИМТЛАГДСАН АШИГ /АЛДАГДАЛ/

	2024	2025
Тайлант үеийн ашиг	(32,242,344.0)	(33,240,901.6)
Хуримтлагдсан ашгийн дүн	(32,242,344.0)	(33,240,901.6)

ТОДРУУЛГА 15. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

	2025
--	------

Борлуулалтын орлого	1,769,056.3
Нийт борлуулалтын орлого	1,769,056.3

ТОДРУУЛГА 16. БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ

	2025
Борлуулалтын өртөг	991,793.5
Нийт борлуулалтын өртөг	991,793.5

ТОДРУУЛГА 17. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

	2025
Цалин хөлс	331,097.8
Нийгмийн даатгалын шимтгэл	40,301.7
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	10,651.9
Томилолтын зардал	14,573.2
Тээврийн зардал	54.5
Элэгдлийн зардал	22,892.6
Бичиг хэргийн зардал	2,289.2
Шатахууны зардал	42,745.1
Засварын зардал	16,987.7
Даатгалын зардал	247.2
Шуудан, холбооны зардал	3,698.5
Мэргэжлийн үйлчилгээний зардал	4,040.5
Сургалтын зардал	350.0
Ашиглалтын зардал	92,182.3
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	54.4
Хүлээн авалтын зардал	26,478.8
Хөдөлмөр аюулгүй байдлын зардал	1,283.6
Бусад	60,779.5
Үйл ажиллагааны зардлын дүн	670,708.5

ТОДРУУЛГА 18. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО, ЗАРДАЛ

	2025
Хүүний орлого	79.1
Бусад орлого	26,061.7
Бусад зардал	31,626.5
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(1,057,143.5)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(32,468.5)

ТОДРУУЛГА 19. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Тайлант хугацаанд 1,769,056.3 мянган төгрөгийн борлуулалтын орлого олж, 991,793.5 мянган төгрөгийн борлуулалтын өртөг тооцож, 79.1 мянган төгрөгийн хүүний орлого олж, 26,061.7 мянган төгрөгийн бусад орлого олж, 670,708.5 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал гарч, 31,626.5 мянган төгрөгийн үйл ажиллагааны бус зардал гарч, (1,057,143.5) мянган төгрөгийн ханшийн зөрүүний гарз гарч, 32,468.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз үүсэж, (988,543.4) мянган төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд жилийн дүнгээр 10,014.2 мянган төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөхөөр тооцоологдсон байна.

Бэлтгэсэн:

Аудитор

Аудиторын туслах



Н.Уранчимэг

Э.Нандин-Эрдэнэ